

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2021.04.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/10-СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Аудитор С.Бат-Эрдэнэ

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 164 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, 155 байгууллага аудит хамрагдсан, 7 байгууллагад итгэл үзүүлсэн, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн ЖДҮДТ Төсвийн хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйгээс, Баянзүрх дүүргийн ЖДҮДТ тайлант онд үйл ажиллагаа явуулаагүйгээс аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан 17 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 138 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 122, “Хязгаарлалттай” 15, “Сөрөг” 1 дүгнэлт өгөв.

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	ТЕЗ	1	1					1		
2	ТТЗ	1	1				1			
3	ТӨҮГ									
4	ТШЗ	96	76	14	4	2	68	7	1	
5	ЗГТС	3	3	0	0	0	2	1		
6	ЗГТС-ийн дэд сангууд	64	58	3	3	0	51	7		
	ДҮН	165	139	17	7	2	122	16	1	0

Гурав. Аудитын үр дүн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 161,649.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 130,348.0 сая төгрөгийн 137 алдааг аудитын явцад залруулж, 425.8 сая төгрөгийн зөрчилд 68 төлбөрийн акт тогтоож, 22,591.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 81, хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлж, 8,284.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 234 зөвлөмж өгөв.

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
				Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
		Тоо	Дүн				
A	1	2	3	5	6	4	7
1	ТЕЗ	4	894.5	-	-	894.5	
2	ТТЗ	1	3.4	3.4			
3	ТШЗ	283	3,298.9	158.4	787.1	2,353.4	
4	ЗГТС, дэд сангууд	98	27,104.8	264.0	21,804.6	5,036.2	
	ДҮН	386	31,301.6	425.8	22,591.7	8,284.1	-

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл:

Алдаа зөрчилтэй асуудал 1

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагч 151 мэдээлэл байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 16 төрлийн 693.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан" 6.4.6-д "худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулах, дээрх зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага Монгол-Солонгосын Политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллага нь кассаар хүлээн авсан өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлээгүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээ, шатлалыг баримтлаагүйгээс цалин илүү олгосон, ажиллагсдын цалингаас суутгавал зохих НДШ, ХХОАТ-ыг дутуу суутгасныг байгууллагын төсвөөс төлсөн, урьдчилж орсон орлогыг данс буруу бүртгэснээс санхүүгийн тайланд орлого дутуу илэрхийлэгдсэн зэрэг зөрчил гаргасны улмаас “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, ..., санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг санал дүгнэлт авсан, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний 26 байгууллагын санхүүгийн тайланд 5 хүртэлх жилийн насжилттай 234.4 сая, 5-аас жилийн насжилттай 660.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 5 -аас жилийн насжилттай 18,805.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх”, 30.1.16-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлагнах” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй өмнөх оноос шилжин ирсэн болон насжилт ихтэй ажиллагчидтай холбогдсон, байгууллага, хувь хүнээс авах авлагын үлдэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс үр дүнтэй хяналт тавьж, сангийн хөрөнгийн эргэлт, үр өгөөжийг дээшлүүлэх гэсэн зөвлөмжүүдийг өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 4

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг боловч үйл ажиллагаа нь бүрэн зогссон Баянзүрх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж, татан буулгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэр гаргуулах, хөрөнгийн үлдэгдлийг шилжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл

ажиллагааг хангах", 14.2.11-д "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагаа нь бүрэн зогссон дээрх байгууллагын өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг татан буулгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх гэсэн зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 5

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 31,301.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн, 16 байгууллагын санхүүгийн тайланд Хязгаарлалттай, 1 байгууллагад Сөрөг санал дүгнэлт өгөгдсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулж, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах гэсэн зөвлөмж өгөв.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД А.АРИУНЗАЯА
ТАНАА

2021.04.26 № 1323
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 31,301.6 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан 20,350.3 сая төгрөгийн зээлийн авлагатай, 987.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд авлагын үлдэгдэл 1,403.6 сая төгрөгөөр илүү бүртгэгдсэн;
- Харьяа 26 байгууллагын санхүүгийн тайланд нэг жилээс дээш насжилттай ажиллагсадтай холбогдсон 49.6 сая, байгууллагаас авах 285.7 сая, төлбөртэй үйлчилгээний 191.2 сая, хувь хүмүүсээс авах 368.0 сая төгрөгийн нийт 894.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зэрэг болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ